МЭДЭЭ · 2024 оны 2-р сарын 16

ДАРХАН-УУЛ АЙМАГТ ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР АМЬТАН АГНАХ, ТЭЭВЭРЛЭХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ГАРАЛТ ӨССӨН БАЙНА



Дархан-Уул аймагт зохих зөвшөөрөлгүйгээр амьтан агнах, тэдгээрийн түүхий эдийг худалдан авах, тээвэрлэх гэмт хэрэг, зөрчлийн гаралт өсөх хандлагатай байна.

Тодруулбал, тус аймгийн прокурорын газраас 2023 онд ховор амьтны гаралтай түүхий эдийг худалдан авсан, тээвэрлэсэн 2 гэмт хэрэг, гэрээ, зөвшөөрөлгүйгээр болон хориотой үед амьтан агнасан, барьсан 37 зөрчилд хяналт тавьсан бол энэ оны 2 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, тээвэрлэсэн гэмт хэрэг 1, гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан зөрчил 7 бүртгэгдэж урьд оны мөн үеэс 85 хувиар өсжээ.

Энэ онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлөөс дурдвал:

- Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт 2024 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр иргэн Н.Э нь ховор амьтны төрөл болох улаан номд орсон Тул загас 2 ширхгийг хууль бусаар агнан, Улаанбаатар хот руу тээвэрлэсэн гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн 1 /Хууль бусаар ан агнах/-д зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж,

- Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн нутгаас Амарын зэвэг, Шивэр хадран, Цулбуурт, Мөнгөлөг хэлтэг, Булуу цагаан, Гутаарь зэрэг загасыг зохих зөвшөөрөлгүй барьж, Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт тээвэрлэсэн 7 иргэнд зөрчлийн хэрэг нээн холбогдох шалгалтын ажиллагааг тус тус явуулж байна.

Иймд иргэд зохих зөвшөөрөлгүйгээр амьтан агнахгүй байх, гарал үүсэл нь тодорхойгүй амьтны гаралтай түүхий эд худалдан авах, тээвэрлэхгүй байхыг анхааруулж байна.

> ***ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ***
>
> ***7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих***
>
> *1.Хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг:*
>
> *1.1.ашигласан;*
>
> *1.2.барьсан;*
>
> *1.3.агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө,орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.*

> ***АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬ***
>
> ***28 дугаар зүйл. Ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих***
>
> *28.1.Энэ хуулийн 21.1-д заасан иргэн зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болно.*
>
> *28.2.Ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих эрхийн бичигт иргэний овог, эцгийн нэр, нэр, агнах, барих агнуурын амьтны зүйл, тоо, агнах, барих хугацаа, газар, төлбөр, хураамжийн хэмжээг нарийвчлан заана.*
>
> *28.3.Ахуйн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих нэг удаагийн эрхийн бичгийг Монгол Улсын иргэнд дор дурдсан хугацаагаар олгоно:*
>
> *28.3.1.шувуу, тарвага агнаж, загас барихад гурав хүртэл хоног;*
>
> *28.3.2.энэ хуулийн 28.3.1-д зааснаас бусад агнуурын амьтан агнах, барихад тав хүртэл хоног.*
>
> *28.4.Энэ хуулийн 28.3-т заасан иргэнд нэг удаагийн эрхийн бичгээр агнах, барихыг зөвшөөрөх агнуурын амьтны тоо хэмжээ нь туурайтан амьтан нэг, тарвага тав, бусад үслэг ан нэг, хөтүү, ятуу, ногтруу шувуу тус бүр арав, ой, хээр, ус, намгийн бусад агнуурын шувуу тав, бусад агнуурын загас арван ширхгээс илүүгүй байна.*

> *28.5.Монгол Улсад түр буюу байнга оршин суугаа гадаадын иргэн Монгол Улсын иргэний адил хэмжээний төлбөр төлж, ахуйн зориулалтаар зөвхөн загас барьж болно.*

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1455